



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 862.

Жаргалтхаан

Т.Сүрэнцэцэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 34/31 тоот тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.5 дахь, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 1, 6 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Түмэнжаргалын Сүрэнцэцэг нь Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтнээр шилжин ажиллах хүсэлт гаргасан тул 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн тус албан тушаалд шилжүүлэн авч томилсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллахыг Т.Сүрэнцэцэгт үүрэг болгосугай.

3.Нийгмийн бодлогын мэргэжилтэн Т.Сүрэнцэцэгийг ТЗ-9 дэх шатлал 1,283,000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөгөөр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 8 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 18 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар тооцож зохих журмын дагуу тооцон олгохыг Нягтлан бодогч Э.Загдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.МӨНХДЭЛГЭР

Data (D:) /A4 tushaal/